МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ
УЛСЫН БАЙЦААГЧИЙН ДҮГНЭЛТ
14251 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
II хороо, Чингисийн өргөн чөлөө 11
Утас: 62263168, Факс: (976-11) 31-23-15
И-мэйл: info@mrtd.gov.mn, https://www.mrtd.gov.mn

2016.11.09 № 38-07-068/09

**“ИЙСТ ЭЖИА ЭНЕРЖИ” ХХК-д**

**САЛБАР ТӨМӨР ЗАМ БАРИХ ТЕХНИКИЙН НӨХЦӨЛ СУДАЛСАН ТУХАЙ ДҮГНЭЛТ**

“Төмөр замын тээврийн тухай хууль”-ийн 12 дугаар зүйлийн 12.4.6 дахь заалт, Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайдын 2012 оны 82 дугаар тушаалаар батлагдсан “Төмөр замын зурвас газар, төмөр замын аюултай бүс, аюулгүйн бүсэд төмөр замын болон бусад объект байрлуулах, үйлдвэрлэл, үйлчилгээ явуулах, нэвтрэх журам”-ын 3.2 дахь хэсэг, Зам, тээврийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2016 оны 95 дугаар тушаалыг тус тус үндэслэн “УБТЗ” ХНН-ийн Толгойт өртөөнд “ИЙСТ ЭЖИА ЭНЕРЖИ” ХХК-ийн хүсэлтийн дагуу салбар төмөр зам барих техникийн нөхцөл, боломжийг судлан үзэж дараах дүгнэлтийг гаргав.

| | |
|---|---|
| 1. Өргөдөл гаргагч: | **“Ийст эжиа энержи” ХХК** |
| 2. Хаяг: | **Улаанбаатар хот, СБД, 1-р хороо, Парк вью резидэнс, 8-1** |
| 3. Утас: | **976-77379771** |
| 4. Суурь бүтэц эзэмшигч: | **“УБТЗ” ХНН** |
| 5. Өртөө, зөрлөгийн нэр: | **“Толгойт” өртөө** |

6. Дүгнэлт:

**Ажлын хэсэг “ИЙСТ ЭЖИА ЭНЕРЖИ” ХХК-ийн хүсэлтийг газар дээр нь судалж үзээд тус компанийн санал болгосон “Оюу ногоон арал” ХХК-ийн эзэмшлийн газар нь Толгойт өртөөнөөс өндрийн төвшин их байгаа тул хэвгий ихтэй, мөн түүнчилэн замын трассын дагуу бусдын эзэмшил газар олон дайрч байгаа тул тус талбайд салбар төмөр зам барих техникийн нөхцлийн боломжгүй гэж дүгнэв.**

Дүгнэлт бичсэн:

Зам, тээврийн хөгжлийн яамны ЗТХХ-ийн
Төмөр замын тээврийн Замын
хяналтын мэргэжилтэн,
Улсын байцаагч С.МАЙДАР

МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТ УЛСЫН БАЙЦААГЧ 38-07-068

го 067